

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХЭА-2022/87/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Чингис хот

2022 он

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар
Утас: 70562112 Цахим хаяг: khentii@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Ахлах аудитор: Н.Туяа
Утас: 99799709 Цахим хаяг: tuyan@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Contents

Contents.....	1
1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
3.7 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.7.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
3.9 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.10 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт	15
4.2 Албан шаардлага	
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
6. Аудитын тайлангийн хавсралт.....	
6.1. Албан шаардлага 2021.03.04 №	ХЭА-2022/87/НА-СТА-ТШЗ
Албан шаардлага 2021.03.04 №	ХЭА-2022/87/НА-СТА-ТШЗ

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2022.03.09 № 170
танай _____ -ны № _____ -т

Г ХЭНТИЙ АЙМГИЙН ӨМНӨДЭЛГЭР
СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Т.БЭРЦЭЦЭГ ТАНАА

Г Аудитын санал дүгнэлт гаргах тухай Г

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭРДЭНЭБААТАР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,721,209.94</u>	<u>2,375,250.00</u>
33	АВЛАГА	548,959.94	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	548,959.94	-
35	БАРАА МАТЕРИАЛ	2,172,250.00	2,375,250.00
354	Хангамжийн материал	2,172,250.00	2,375,250.00
35410	Бичиг хэргийн материал	195,500.00	213,500.00
35420	Аж ахуйн материал	1,976,750.00	2,161,750.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,881,975.44</u>	<u>12,233,292.50</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,881,975.44	12,233,292.50
392	Биет хөрөнгө	2,881,975.44	12,233,292.50
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	4,320,000.00	14,132,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(2,800,416.52)	(2,951,999.50)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	3,211,000.00	3,211,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(1,848,608.04)	(2,157,708.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>5,603,185.38</u>	<u>14,608,542.50</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>2,269,734.05</u>	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,269,734.05	-
413	Өглөг	2,269,734.05	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	591,157.05	-
4136	Бусад өглөг	1,678,577.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	717,000.00	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	961,577.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>3,333,451.33</u>	<u>14,608,542.50</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	3,333,451.33	14,608,542.50
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	634,000.00	634,000.00
51101	Өмч: - төрийн	634,000.00	634,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	2,671,866.66	13,946,957.83
51210	Өмнөх үеийн үр дүн	2,671,866.66	2,671,866.66
51220	Тайлант үеийн үр дүн	-	11,275,091.17
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	27,584.67	27,584.67
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>5,603,185.38</u>	<u>14,608,542.50</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	87,006,800.00	107,078,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	87,006,800.00	107,078,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,000,000.00	3,300,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,000,000.00	3,300,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,000,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	79,006,800.00	103,778,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	79,006,800.00	103,778,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	87,432,159.03	95,803,508.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	87,432,159.03	95,803,508.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	83,658,421.97	81,379,151.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	55,854,949.83	54,762,253.79
210101	Үндсэн цалин	39,240,804.83	45,059,347.27
210102	Нэмэгдэл	1,550,504.00	-
210103	Унаа хоолны хөнгөлөлт	85,010.00	-
210104	Урамшуулал	14,978,631.00	9,702,906.52
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,724,515.22	7,399,768.65
210201	Тэтгэврийн даатгал	4,571,565.00	5,203,665.61
210202	Тэтгэмжийн даатгал	537,831.00	549,111.23
210203	ҮОМШӨ-ний даатгал	430,264.00	431,405.90
210204	Ажилгүйдлийн даатгал	107,566.00	181,262.51
210205	Эрүүл мэндийн даатгал	1,077,289.22	1,034,323.40
2104	Хангамж, бараа материалын зардал	5,455,690.00	6,687,566.00
210401	Бичиг хэрэг	1,490,200.00	666,500.00
210402	Тээвэр, шатахуун	3,805,290.00	5,942,086.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,400.00	78,980.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	156,800.00	-
2107	Томилолт, зочны зардал	709,000.00	1,164,000.00
210702	Дотоод албан томилолт	709,000.00	1,164,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,440,017.00	2,609,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,440,017.00	2,285,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	324,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,474,249.92	8,756,462.94
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,204,150.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,804,000.00	8,295,780.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	466,099.92	460,682.94
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,773,737.06	14,424,357.45
2132	Бусад урсгал шилжүүлэг	759,000.00	4,989,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	759,000.00	4,989,600.00

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,014,737.06	9,369,757.45
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,014,737.06	9,369,757.45
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	65,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	65,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(425,359.03)	11,275,091.17
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(425,359.03)	11,275,091.17

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	634,000.00	27,584.67	5,461,711.69	6,123,296.36
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	634,000.00	27,584.67	5,461,711.69	6,123,296.36
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(2,789,845.03)	(2,789,845.03)
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	634,000.00	27,584.67	2,671,866.66	3,333,451.33
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	634,000.00	27,584.67	2,671,866.66	3,333,451.33
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	634,000.00	27,584.67	2,671,866.66	3,333,451.33
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	11,275,091.17	11,275,091.17
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	634,000.00	27,584.67	13,946,957.83	14,608,542.50

4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	84,111,300.00	107,078,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	84,111,300.00	107,078,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,104,500.00	3,300,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,000,000.00	3,300,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,104,500.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	79,006,800.00	103,778,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	79,006,800.00	103,778,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	84,111,300.00	107,078,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	84,111,300.00	107,078,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	79,896,562.94	93,477,242.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	54,631,882.80	54,973,067.90
210101	Үндсэн цалин	31,543,477.82	32,975,005.52
210102	Нэмэгдэл	7,814,703.98	12,295,155.86
210103	Унаа хоолны хөнгөлөлт	295,010.00	-
210104	Урамшуулал	14,978,691.00	9,702,906.52
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,031,098.14	7,399,728.65
210201	Тэтгэврийн даатгал	4,175,871.33	5,215,778.11
210202	Тэтгэмжийн даатгал	464,226.63	536,958.73
210203	ҮОМШӨ-ний даатгал	371,738.95	439,503.56
210204	Ажилгүйдлийн даатгал	113,405.96	103,042.77
210205	Эрүүл мэндийн даатгал	905,855.27	1,104,445.48
2104	Хангамж, бараа материалын зардал	5,531,000.00	6,423,216.00
210401	Бичиг хэрэг	1,540,200.00	539,500.00
210402	Тээвэр, шатахуун	3,805,600.00	5,774,736.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,400.00	108,980.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	181,800.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	9,997,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	9,997,000.00
2107	Томилолт, зочны зардал	709,000.00	1,164,000.00
210702	Дотоод албан томилолт	709,000.00	1,164,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,818,632.00	5,781,450.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,494,632.00	5,457,450.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	324,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,174,950.00	7,738,780.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,240,950.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,934,000.00	7,738,780.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,214,737.06	13,601,357.45
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,200,000.00	4,166,600.00

Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,200,000.00	4,166,600.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,014,737.06	9,369,757.45
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,014,737.06	9,369,757.45
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	65,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	65,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	103,778,600.00	94,408,842.55	9,369,757.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	103,778,600.00	94,408,842.55	9,369,757.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	99,612,000.00	90,242,242.55	9,369,757.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	63,103,200.00	54,973,067.90	8,130,132.10
210101	Үндсэн цалин	25,174,300.00	32,975,005.52	(7,800,705.52)
210102	Нэмэгдэл	14,058,500.00	12,295,155.86	1,763,344.14
210104	Урамшуулал	17,574,100.00	9,702,906.52	7,871,193.48
210105	Гэрээт ажлын хөлс	6,296,300.00	-	6,296,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,518,900.00	7,399,728.65	1,119,171.35
210201	Тэтгэврийн даатгал	5,994,800.00	5,215,778.11	779,021.89
210202	Тэтгэмжийн даатгал	631,000.00	536,958.73	94,041.27
210203	ҮОМШӨ-ний даатгал	504,800.00	439,503.56	65,296.44
210204	Ажилгүйдлийн даатгал	126,200.00	103,042.77	23,157.23
210205	Эрүүл мэндийн даатгал	1,262,100.00	1,104,445.48	157,654.52
2104	Хангамж, бараа материалын зардал	3,710,000.00	3,623,216.00	86,784.00
210401	Бичиг хэрэг	516,500.00	539,500.00	(23,000.00)
210402	Тээвэр, шатахуун	3,005,000.00	3,004,736.00	264.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	188,500.00	78,980.00	109,520.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,000,000.00	9,997,000.00	3,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,000,000.00	9,997,000.00	3,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,190,600.00	1,164,000.00	26,600.00
210702	Дотоод албан томилолт	1,190,600.00	1,164,000.00	26,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,350,500.00	5,346,450.00	4,050.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,350,500.00	5,022,450.00	328,050.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		324,000.00	(324,000.00)
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,738,800.00	7,738,780.00	20.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,738,800.00	7,738,780.00	20.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	103,778,600.00	94,408,842.55	9,369,757.45
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	103,778,600.00	94,408,842.55	9,369,757.45
132001	Орон нутгийн төсвөөс	103,778,600.00	94,408,842.55	9,369,757.45

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,300,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,300,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,235,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,800,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,770,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	30,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	435,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	435,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	65,000.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	65,000.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	65,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,300,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,300,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,300,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Н.Туяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын чиг үүргийг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд “Сум, дүүргийн Хурал нь Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, яам, агентлаг, дээд шатны Хуралд болон төрийн эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтанд хуулиар харьяалуулснаас бусад тухайн нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн болон зохион байгуулалтын ямар ч асуудлыг хэлэлцэж бие даан шийдвэрлэх эрхтэй бөгөөд дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж хэрэгжүүлнэ: 18.1.1. Хурлын зохион байгуулалт, хяналт шалгалтын талаар, 18.1.2. нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн талаар, 18.1.3. орон нутгийн өмчийн талаар, 18.2. Хуулиар тусгайлан эрх олгогдсон тохиолдолд захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлж, мөрдүүлнэ, 18.3. Сум, дүүргийн Хурал нь хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна

Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хэнтий аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас Өмнөдэлгэр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит гүйцэтгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 85.8 сая төгрөгөөс 1 хувиар буюу 0.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 0.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 14.6 сая төгрөг болж, өмнөх оноос 9.0 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, үндсэн хөрөнгө, хуримтлагдсан үр дүнгийн данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	0.5		(0.5)
Урьдчилгаа			-
Бараа материал	2.2	2.4	0.2
Үндсэн хөрөнгө	2.9	12.2	9.3
Нийт хөрөнгө	5.6	14.6	9.0
Өр төлбөр	2.3	0.0	(2.3)
Засгийн газрын оруулсан капитал	0.6	0.6	-
Хуримтлагдсан үр дүн	2.7	14.0	11.3

Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	0.0	0.0	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	5.6	14.6	9.0

Авлага дансны үлдэгдэл буурсан нь өмнөх оны нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг барагдуулсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 2.4 сая төгрөг болж, 0.2 сая төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн дансанд 9.8 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг худалдан авч үлдэгдэл 12.2 сая төгрөг болсон байна.

Хуримтлагдсан үр дүн дансны үлдэгдэл 14.0 сая төгрөг болж, 11.3 сая төгрөгөөр буюу тайлант үеийн үр дүнгээр өссөн байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 20.1 сая төгрөгөөр буюу 23.1 хувиар өссөн нь урсгал үйл ажиллагааны санхүүжилт 24.8 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой байна. Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 4.0 сая төгрөгөөр, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 0.7 сая төгрөгөөр буурсан байна.

Нийт зардал 95.8 сая төгрөг болж өмнөх оноос 8.4 сая төгрөгөөр буюу 9.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь урсгал шилжүүлэг 10.6 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 101.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 2.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж 104.2 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 103.8 сая төгрөгийн төсөв баталсныг орон нутгийн төсвөөс 103.8 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 103.8 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 94.4 сая төгрөгийг зарцуулж, 9.4 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 3.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж зарцуулсан байна. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.7.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд нийт мэдээлбэл зохих 133.6 сая төгрөгийн 49 мэдээллээс 14.0 сая төгрөгийн 19 мэдээллийг мэдээлж, санхүүжилтийн орлогын 95.6 сая төгрөгийн 7 гүйлгээ, 5 сая төгрөгөөс дээш 9.0 сая төгрөгийн 1 гүйлгээ, хөрөнгө зарцуулах тухай 14.9 сая төгрөгийн 19 шийдвэрийг, 1-3 сард төсвийн гүйцэтгэлийг, нийт 119.5 сая төгрөгийн 30 мэдээллийг мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж, 1 албан шаардлага, өгснөөс албан шаардлагыг хэрэгжүүлж, шилэн дансны мэдээллийг бүрэн мэдээлэх зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.10 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 122.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 122.6 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлсэн.

4.2 Албан шаардлага

1. Тайлант онд нийт мэдээлбэл зохих 133.6 сая төгрөгийн 49 мэдээллээс 14.0 сая төгрөгийн 19 мэдээллийг мэдээлж, санхүүжилтийн орлогын 95.6 сая төгрөгийн 7 гүйлгээ, 5 сая төгрөгөөс дээш 9.0 сая төгрөгийн 1 гүйлгээ, хөрөнгө зарцуулах тухай 14.9 сая төгрөгийн 19 шийдвэрийг, 1-3 сард төсвийн гүйцэтгэлийг, нийт 119.5 сая төгрөгийн 30 мэдээллийг мэдээлээгүй байна.

2. Батлагдсан төсвийн хэмжээнд тэвчиж болох 3.1 сая төгрөгийг хэмнэж ажиллаагүй байна.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1	3.1					1	3.1		
	Дүн	1	3.1					1	3.1		
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1	119.5					1	119.5		
	Дүн	1	119.5					1	119.5		
	Нийт дүн	2	122.6					2	122.6		



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 09

Дугаар 104/А2370447
ХТ-А 2022/87/НА -СГА -ТЦЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Батлагдсан төсвийн хэмжээнд тэвчиж болох 3.1 сая төгрөгийг хэмнэж ажиллаагүй байна.

Энэ нь Монгол улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1 дугаар зүйлийн 1.1-д "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах", 1.5 "салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх" гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Өмнөдэлгэр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга Т.Бэрцэцэг, нягтлан бодогч Ц.Бямбасүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Н.ТУЯА

Д.ОЮУНТУЯА

2317144297
СЮА0046 9074082



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 09

Дугаар 103/А2370447
ХЭА-2022/87/НА-СТА 7ЦЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд нийт мэдээлбэл зохих 133.6 сая төгрөгийн 49 мэдээллээс 14.0 сая төгрөгийн 19 мэдээллийг мэдээлж, санхүүжилтийн орлогын 95.6 сая төгрөгийн 7 гүйлгээ, 5 сая төгрөгөөс дээш 9.0 сая төгрөгийн 1 гүйлгээ, хөрөнгө зарцуулах тухай 14.9 сая төгрөгийн 19 шийдвэрийг, 1-3 сард төсвийн гүйцэтгэлийг, нийт 119.5 сая төгрөгийн 30 мэдээллийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.10-д “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулдаггүй зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Өмнөдэлгэр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн Т.Бэрцэцэг, нягтлан бодогч Ц.Бямбасүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР

Н.ТУЯА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ОУУНТУЯА

2317144297